



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 1/03

Хэрлэн сум

**Итгэмжлэгдсэн төлөөлөгч  
томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэх ТУШААХ нь:

1. "Өндөрхаан өргөө" ХХК-аас Хэнтий аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасантай холбогдуулан хариуцагчаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, 20.1.4, 20.1.5, 20.1.6, 20.1.7, 20.2.1, 20.2.2, 20.2.3, 20.2.4, 20.2.5, 20.2.6, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.2.1 дэх заалтуудад заасан бүрэн эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар), Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн (Н.Үнэнбат) нарт олгож аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилсугай.

2. Захиргааны хэргийн хянан шийдвэрлэх үйл ажиллагаанд хариуцагчийг бүрэн төлөөлж, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр шүүх хуралд оролцож хэргийн шийдвэрлэлтийн талаар тухай бүр танилцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар), Хэнтий аймгийн Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн (Н.Үнэнбат) нарт даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА